



НИЙСЛЭЛИЙН
“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулан
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 13.4.1 дэх заалт, Ёс зүйн дэд хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын дүрмийн 9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан хавсралтаар баталсугай.

2.Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний гишүүдийг урамшуулан үндсэн цалинг харгалзан даргад 20 хувь, гишүүн, нарийн бичгийн даргад тус бүр 10 хувийн урамшууллын мөнгийг холбогдох зардлаас гарган сар бүр олгохыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Д.Пүрэвжав)-т зөвшөөрсүгэй.

3.Тушаалыг гарсан өдрөөс эхлэн мөрдөж, ажилтны Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулан, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Ц.Гүрбадам)-нд үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарснаар Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн “Тушаал хүчингүй болгож, дүрэм шинэчлэн батлах тухай” А/69 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт, 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Тушаалд өөрчлөлт оруулан батлах тухай” А/04 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

1725010710